

**МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН БҮГД  
НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭРИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР ХООРОНД МОНГОЛ УЛСААС БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД  
УЛСАД ЭКСПОРТЛОХ ҮХРИЙН МАХНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХОРИО ЦЭЭР, МАЛ  
ЭМНЭЛЭГ, АРИУН ЦЭВРИЙН НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ПРОТОКОЛ**

Монгол Улсын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид МХЕГ гэх/, БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн ерөнхий газар /цаашид ЧХШХЦЕГ гэх/ нөхөрсгөөр хэлэлцэн Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үхрийн мах /цаашид мах гэх/ экспортлохтой холбогдсон хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн нөхцөлийн талаар дараах шаардлагуудыг харилцан тохиролцов. Үүнд:

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ**

МХЕГ нь БНХАУ-д экспортлох махны хяналт шалгалт, хорио цээрийг хариуцаж, мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ**

МХЕГ мал нядлах болон боловсруулах үйлдвэрүүдийн холбогдох хууль, дүрэм журмууд, экспортлох махны хяналт шалгалт, хорио цээрийн хөтөлбөр, аргачлал, журам, стандартыг ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ. МХЕГ хяналт шалгалтын тамга, мал эмнэлгийн гэрчилгээ, албан ёсны малын эмчийн гарын үсэг, тэмдгийн хуулбарын загварыг ЧХШХЦЕГ-т урьдчилан өгнө.

Гарын үсэг, тэмдэгэнд өөрчлөлт, нэмэлт оруулах тохиолдолд нэг сарын өмнө ЧХШХЦЕГ-т мэдэгдэнэ.

МХЕГ мах экспортлох компанийн байршил, бүтэц, үйлдвэрлэл, экспортын хүчин чадал, аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын систем зэрэг мэдээллийг ЧХШХЦЕГ-т хүргүүлэх үүрэгтэй. МХЕГ мах экспортлох аж ахуйн нэгж тус бүрийн үйлдвэрлэл, экспортын хэмжээ, хяналт шалгалт хийсэн тухай болон чанарын шаардлага хангаагүй болон тээвэрлэлтийн талаарх мэдээллийг улирал бүр ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ**

МХЕГ энэхүү протоколын 4, 5 дугаар зүйлд заасан малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах тогтолцооны талаарх мэдээллийг хүргүүлэхээс гадна энэ талаар жилийн тайланг ЧХШХЦЕГ-ын хүргүүлнэ.

МХЕГ шүлхийн бүсчилсэн хяналтын арга хэмжээ, шүлхий өвчнөөр тайван вакцин хэрэглэдэггүй бүс нутагт халдвар орохоос сэргийлсэн хяналт шалгалт, хорио цээрийн болон төлөвлөгөөт вакцинжуулалт гэх мэт бусад арга бусад хэмжээний талаарх мэдээллийг ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ.

МХЕГ шүлхий өвчнөөр тайван бүс нутаг дахь тандалтын талаарх жилийн тайлангаа ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ.

МХЕГ үлдэгдлийн хяналт, шалгалтын үндэсний төлөвлөгөөг хэрэгжүүлж өмнөх жилийн үлдэгдлийн хяналт, шалгалтын тайланг ЧХШХЦЕГ-ын хүргүүлнэ.

МХЕГ нянгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж өмнөх жилийн нянгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний тайланг ЧХШХЦЕГ-ын хүргүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд ЧХШХЦЕГ мэргэжлийн багийг дээр дурдсан хяналтын тогтолцоо, үлдэгдлийн хяналт шалгалтын хөтөлбөрийг баталгаажуулах үүднээс Монголд илгээж болно. МХЕГ шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ**

МХЕГ дараах зүйлсийг албан ёсоор баталгаажуулна.

1. Монгол Улсын газар нутагт үхрийн мялзан, үхрийн цээж, үхрийн тархи сархиатах, рифт хөндийн халуурал, лимфийн зангилаат үрэвсэл, мялзан төст зэрэг өвчнөөр тайван болохыг.

МХЕГ шүлхий өвчний бүсчилсэн арга хэмжээ, шүлхий өвчнөөр тайван бүс нутагт сүүлийн 12 сар шүлхийн өвчин илрээгүй болохыг.

МХЕГ ДМАЭМБ-ын кодын дагуу үхрийн тархи сархиатах өвчнийг хянах, сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, уг хяналтаар Монгол Улс үхрийн тархи сархиатах өвчний тохиолдол байхгүй болохыг.

2. Монгол Улс нядалгаанд орсон үхэр хаана төрж, бойжсон, тэдгээрийг хаанаас гаралтай болохыг тогтоох үүднээс үр дүнтэй ул мөрийг мөрдөн мөшгөх тогтолцоог байгуулсан болохыг.

3. Монгол Улс хивэгч амьтны гаралтай /сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад/ зөвхөн арьс, ширнээс гарган авсан цэлцэгнүүр, коллаген, дикальцифосфат /уураг болон өөхний үлдэгдэлгүй/ агуулсан тэжээлээр хивэгч амьтныг тэжээхийг хориглосон болохыг; дээрх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо байгаа болохыг.

4. Хэрэв дээрх өвчнүүд Монгол Улсад гарсан, Монгол Улс дахь шүлхийгээр тайван бүс нутагт шүлхий өвчин гарсан эсвэл МХЕГ болон ЧХШХЦЕГ аюултай гэж үзсэн үхрийн халдварт өвчин тархсан, хүнсний ноцтой бохирдол гарсан үед МХЕГ, ЧХШХЦЕГ-т даруй мэдэгдэж нөхцөл байдлын талаар нарийвчилсан тайланг хүргүүлэн, олон улсын шаардлагын дагуу Хятад руу гаргах экспортыг түр зогсоох ба бохирлогдсон байж болзошгүй хөлдөөсөн махыг эргүүлэн татна.

Монгол Улсад ДМАЭМБ-ийн өвчний жагсаалтад орсон үхрийн бусад өвчин гарсан, хүнсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулахуйц тохиолдол үүссэн үед МХЕГ ЧХШХЦЕГ-т даруй мэдэгдэж нөхцөл байдлын талаар нарийвчилсан тайланг хүргүүлэн олон улсын шаардлагын дагуу Хятад руу гаргах экспортыг түр зогсоох ба бохирлогдсон байж болзошгүй хөлдөөсөн махыг эргүүлэн татна.

Хятадад экспортыг сэргээхийн тулд МХЕГ өвчин болон хоол хүнсний бохирдлын нөхцөл байдал, бохирдол болон өвчнийг хяналтад авсан тухай арга хэмжээний талаар мэдээллийг агуулсан тайланг ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ. Үүний дараа олон улсын шаардлагын дагуу ЧХШХЦЕГ-тай экспортыг сэргээх нөхцөл байдлын талаар хэлэлцээр хийнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

Хятадад экспортлох махны үйлдвэрт нядлагдах мал нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Үхэр нь Монгол Улсын шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүс нутагт төрж бойжсон байх, мөрдөн тогтоож болохуйц давтагдахгүй таних тэмдэгтэй байна.
2. Экспортлох аймгууд нь дараах нөхцөл байдлыг хангасан байна:
  - i. ЧХШХЦЕГ албан ёсоор тухайн аймгийг мах экспортлохыг баталсан байх.
  - ii. Шүлхий өвчнөөр тайван аймгуудад бусад аймгаас сүүлийн 12 сарын хугацаанд салаа туурайтай амьтан ороогүй болохыг.
  - iii. Тухайн аймаг үлдэгдлийн хяналт шалгалтын үндэсний төлөвлөгөө, эсвэл экспортлох маханд хийх үлдэгдлийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд хамрагдсан байх. Энэхүү төлөвлөгөөний үр дүнг үндэслэн Хятадад экспортлох маханд ямар нэгэн химийн бодисын үлдэгдэл, эм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болохуйц хортой болон аюултай үлдэгдэл агуулаагүй болохыг баталгаажуулах.
3. Сум болон дүүргээс нийлүүлэхэд дараах шаардлагыг хангасан байх.
  - i. Сум, дүүрэг нь сүүлийн 6 сарын хугацаанд ямар нэгэн мал, амьтны өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоогоогүй байх.
  - ii. Сум, дүүрэгт сүүлийн 6 сарын хугацаанд цэврүүт амтас, хэл хөхрөх, сүрьеэ, боом, галзуу, бруцеллэз, Ауски өвчин, ку-чичрэг, зүрх усжих (heartwater) болон иж сүрьеэ зэрэг өвчин гараагүй байх.
4. Мал нь нядлагдахаас доод тал нь 6 сарын өмнө тухайн суманд байрласан байх. Нядалгаанд орохоос 14 хоногийн өмнө эсвэл түүнээс урт хугацаанд боомын амьд вакцинд таригдаагүй байх.
5. Мал нь хивэгч малын гаралтай /сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад/ зөвхөн арьс, ширнээс гарган авсан цэлцэгнүүр, коллаген, дикальцифосфат /уураг болон өөхний үлдэгдэлгүй/ агуулсан тэжээлээр тэжээгдээгүй байх болон Хятад, Монгол Улсад хориотой малын эм, хүнсний нэмэлт хэрэглээгүй байх.
6. Нядалгааны өмнөх болон дараах хяналтаар үхрийн сүрьеэ, боом, бруцеллэз зэрэг өвчний шинж тэмдэг илрээгүй байх. Хэрэв нядалгааны өмнөх болон дараах хяналтаар эдгээр өвчнүүд илэрсэн тохиолдолд тухайн малтай хамт байсан бусад малын махыг Хятад руу экспортолж болохгүй.

## ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Махыг БНХАУ-д экспортлох махны үйлдвэр (нядалгаа, боловсруулах, хадгалах) нь шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэггүй бүс нутагт байрлах бөгөөд тухайн аймаг МХЕГ, ЧХШХЦЕГ-аас баталгаажуулсан байна. Хятад, Монгол Улсын баталсан хууль тогтоомжийн дагуу эрүүл ахуй, мал эмнэлгийн шаардлагыг хангасан байна. Экспортлох үйлдвэрүүд нь "БНХАУ-д хүнс импортлох гадаадын хүнсний үйлдвэрийн бүртгэлийн журам"-ын дагуу БНХАУ-ын Гэрчилгээжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн газарт бүртгэгдсэн байна. Тухайн бүртгэлд бүртгэгдээгүй үйлдвэрийн махан бүтээгдэхүүнийг Хятадад экспортлох боломжгүй.

## ДОЛДУГААР ЗҮЙЛ

Монгол Улсын албан ёсны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. БНХАУ болон Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын дагуу Хятадад экспортлох махны зориулалтаар нядлагдах малд нядалгааны өмнөх болон дараах хяналтыг хийнэ.
2. Бод мал нь энэхүү протоколын 4, 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байх, мал, амьтны халдварт өвчин, шимэгч хорхойн эмнэл зүйн шинж тэмдэггүй, гулууз болон дотор эрхтэнд ямар нэгэн эмгэг өөрчлөлтгүй байна.
3. Нядлагдсан малын гулууз махыг шулахаас өмнө целсийн +2 оос дээш хэмд доод тал нь 24 цаг сэврээнэ. Гулууз махны рН нь ясгүй махны гүнд 5.9-өөс ихгүй, гулууз мах нь тунгалгийн зангилаа болон булчирхайн эдгүй болохыг баталгаажуулна.
4. Мах боловсруулах үйл ажиллагаа нь МХЕГ-ын хяналт дор хийгдэх бөгөөд мах нь НАССР-д суурилсан чанарын хяналтын тогтолцооны хөтөлбөртэй үйлдвэрт бэлтгэгдсэн, ямар нэгэн өвчин үүсгэгч бичил биетээр бохирдоогүй, БНХАУ болон Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын шаардлагыг хангасан болохыг баталгаажуулна.
5. Бүтээгдэхүүн дэх мал эмнэлгийн эм, пестицид, хүнд металл, хортой болон аюултай бодисын үлдэгдлийн хэмжээ БНХАУ болон Монгол Улсад зөвшөөрөгдөх үлдэгдлийн дээд хэмжээнээс хэтрээгүй, хоёр улсад хэрэглэхийг хориглосон бодис агуулаагүй болохыг баталгаажуулна.
6. Мах нь хүний хэрэгцээний шаардлагыг хангасан, аюулгүй болохыг баталгаажуулна.
7. Энэхүү зүйлийн 1-6 дахь шаардлагыг зөрчсөн бол холбогдох үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг нэн даруй зогсоож ЧХШХЦЕГ-т мэдэгдэнэ. МХЕГ зөрчлийн шалтгааныг мөрдөн тогтоож, бохирдсон байж болзошгүй бүтээгдэхүүнийг буцаан татах зэрэг арга хэмжээ авна.

## НАЙМДУГААР ЗҮЙЛ

Хятадад экспортлох зориулалтын үхрийг энэхүү протоколын 4 болон 5 дугаар зүйлийн шаардлага хангаагүй бусад үхэртэй хамт нядалж болохгүй. Хятадад экспортлох махыг энэхүү протоколын 4, 5 болон 7 дугаар зүйлийн шаардлага хангаагүй малаас бэлтгэгдсэн махтай хамт боловсруулж болохгүй. Хятадад экспортлох мах нядалгааны дамжлага бүрт болон хадгалах явцад танигдахаар байна. Хятадад экспортлох махыг бусад махнаас тусдаа, зориулалтын өрөөнд хадгална.

## ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Экспортлох махны дотор болон гаднах баглаа, боодол нь олон улсын эрүүл ахуйн стандартад нийцсэн хоргүй, аюулгүй шинэ материалаар хийгдсэн байна. Гадна болон дотор баглаа боодлын шошго дээр гарал үүслийн улс, үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн нэр, бүртгэлийн дугаар, багцын дугаарыг хятад хэлээр бичсэн байна. Гаднах савлагаан дээр Хятад хэлээр тодорхойлолт, гарал үүслийн нутаг (муж/аймаг/хот) үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон нөхцөл зэрэг мэдээллийг агуулсан шошго

наана. Хүрэх газар нь БНХАУ-д гэж байна. Бүтээгдэхүүн нь МХЕГ-ын хорио цээрийн тамгаар тамгалагдсан байна.

#### **АРАВДУГААР ЗҮЙЛ**

Хятадад экспортлох махны савлалт, хадгалалт, тээвэрлэлт зэрэг бүхий л экспортлох үйл явц нь ариун цэврийн шаардлагад нийцсэн байх ба хорт болон аюултай бодисоор бохирлогдохоос сэргийлсэн байна. Тээвэрлэлтийн явцад мах нь өвчний улмаас хязгаарлалтад орсон эсвэл тандалтад хамрагдаж байгаа нутаг дэвсгэрээр дайран өнгөрч болохгүй. Барааг савлаж чингэлэгт хийсний дараа МХЕГ-ын албан ёсны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн хяналт дор лацлагдаж, битүүмжлэгдэнэ. Лацны дугаарыг мал эмнэлгийн гэрчилгээнд тэмдэглэсэн байна. Тээвэрлэлтийн явцад баглаа боодлыг сольж, онгойлгож болохгүй. Мөн хөлдөөсөн махны гүний хэм нь -18 хэмээс ихгүй байна.

#### **АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ**

Хятадад экспортлох махны чингэлэг бүрт бүтээгдэхүүн нь энэхүү протоколын холбогдох шаардлагууд, Монгол, Хятадын мал эмнэлгийн ариун цэвэр, нийгмийн эрүүл мэндтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, холбогдох шаардлагуудыг хангасан болохыг тодорхойлсон албан ёсны мал эмнэлгийн гэрчилгээний эх хувийг дагалдуулж өгнө. Хоёр тал харилцан тохиролцсон гэрчилгээ, цахим мэдээллийг ЧХШХЦЕГ-т хүргүүлнэ.

#### **АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ**

Шаардлагатай тохиолдолд Хятадад мах экспортлох хяналт, шалгалт, хорио цээрийг баталгаажуулах зорилгоор тухайн нутаг дэвсгэр, үйлдвэр (нядалгаа, боловсруулах, хадгалах), экспортолж буй боомтод Хятадын талаас малын эмч томилж ажиллуулж болно. МХЕГ шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.

#### **АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ**

Махыг ЧХШХЦЕГ-аас баталгаажуулсан боомтоор экспортолно. Хэрэв ЧХШХЦЕГ махыг энэ протоколын шаардлагыг хангаагүй болохыг олж тогтоовол нэн даруй МХЕГ-т мэдэгдэх ба бүх барааг буцааж эсвэл БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу устгалын арга хэмжээг авч болно. МХЕГ нь зөрчлийг арилгуулах, дахин гаргахгүйн тулд хэрэгжүүлсэн арга хэмжээ ЧХШХЦЕГ-т мэдэгдэж, шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг эргэн татаж цаашид энэ чиглэлээр хоёр тал хамтран ажиллана.

#### **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ**

Энэхүү протоколд дурдсан үхрийн мах гэдэгт ястай болон ясгүй хөлдөөсөн үхрийн махыг хэлэх ба толгой, шийр, хүзүү, сээр нурууны нугас, дотор эрхтэн, хэвлийн гялтан хальс бусад дайвар бүтээгдэхүүн ороогүй болно.

#### АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү протоколд хоёр тал харилцан зөвшилцөж, нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт оруулсан хэсгийн хүчин төгөлдөр болох хугацааг хоёр тал зөвшилцөж шийдвэрлэнэ.

#### АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

ЧХШХЦЕГ болон МХЕГ-ын аль нэг нь уг протоколыг хүчингүй болгох саналтай бол 6 сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

#### АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

ЧХШХЦЕГ болон МХЕГ-ын аль нэг нь энэхүү протоколын талаар нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг албан ёсоор гаргана. Зөвлөлдөх уулзалт болох газар, огноог хоёр тал зөвшилцөж шийдвэрлэнэ.

#### АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Энэхүү протокол нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү протоколыг 2016 оны 08 дугаар сарын 29-ний өдөр монгол, хятад, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэрэв орчуулгын тал дээр санал зөрвөл англи хэл дээрх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН

ЕРӨНХИЙ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН:

БНХАУ-ЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ,

ШАЛГАЛТ ХОРИО ЦЭЭРИЙН

ЕРӨНХИЙ ГАЗРЫГ ТӨЛӨӨЛӨН:



**蒙古国国家技术监督总局和中华人民共和国国家质量监督检验检疫总局关于中国从蒙古国输入牛肉的  
检验检疫和兽医卫生条件议定书**

蒙古国国家技术监督总局(以下简称“蒙方”)和中华人民共和国国家质量监督检验检疫总局(以下简称“中方”)经过友好协商,就中国从蒙古国输入牛肉的检验检疫和兽医卫生条件达成协议如下:

**第一条**

蒙方负责向中国输出牛肉的检验检疫工作,并出具卫生证书。

**第二条**

蒙方负责向中方提供有关蒙古国肉类屠宰、加工和储存企业管理的法律法规,出口牛肉的检验检疫项目、方法、程序和标准,以及检疫印章印模、卫生证书样本、授权兽医的签名式样、检讫标记等资料给中方备案。以上如有更改、变换、应至少提前一个月向中方通报。

蒙方负责向中方提供对华出口牛肉企业的基本情况、位置和布局、生产和出口供应能力、安全卫生管理体系等基础信息;并每个季度向中方提供各企业牛肉生产及对华出口情况、官方对企业的监管情况、发现的不合格情况及相关处置措施等动态信息。

**第三条**

根据中方要求,蒙方负责向中方提供蒙古国有关本议定书第四条、第五条所列动物疫病的防控体系,并定期向中方通报年度动物疫病防控

情况报告。

蒙方负责向中方提供其口蹄疫区域化管理的政策、检验检疫措施及其它包括实施免疫计划在内的保证无疫区无疫状态的措施，并定期向中方通报年度口蹄疫无疫区的疫情监测报告。

蒙古国实施了国家残留监控计划，并定期向中方提供其年度残留监控计划和上一年度监控报告。

蒙古国实施了国家微生物监控计划，并定期向中方提供其年度微生物监控计划和上一年度监控报告。

必要时，中方可派员到蒙古国，对其上述体系或计划的实施情况进行实地核查评估。蒙方应提供必要的协助和便利条件。

#### 第四条

蒙方确认：

（一）蒙古国境内无牛瘟、牛传染性胸膜肺炎，牛海绵状脑病、裂谷热、牛结节性疹、小反刍兽疫。

蒙古国对口蹄疫实施区域化管理，无疫区内过去 12 个月内无口蹄疫病例。

蒙古国按照世界动物卫生组织（OIE）的规定对牛海绵状脑病进行了监测和防控，监测结果表明蒙古国无牛海绵状脑病病例。

（二）蒙古国已建立有效的追溯体系，确保可以追溯到屠宰牛的出生和生长的地区（苏木）和动物群体。

（三）蒙古国已实施了饲料禁令禁止使用反刍动物源性成份（奶及奶制品、皮张制成的明胶和胶原、无蛋白和脂肪残留的磷酸二钙除外）饲喂反刍动物，并有有效的监督体系以保证该项禁令的实施。

(四) 如蒙古国境内发生上述疾病、或其规定的口蹄疫无疫区内发生口蹄疫、或发生中蒙双方关注的与牛相关的其它恶性传染病时，或发生严重的食品污染事件时，蒙方应立即通知中方，提供详细报告并按国际惯例暂停对华出口，并召回可能受污染的产品。

如蒙古国境内发生除上述疫病以外的 OIE 规定的其它须通报动物疫病并严重影响到牛的健康，或发生食品安全污染事件时，蒙方也应立即通知中方，提供详细报告并按照国际惯例暂停受影响区域的肉类产品对华出口，并召回可能受污染的产品。

蒙方为恢复其产品的出口，应向中方提供关于疫情或污染状况、控制措施及疫情或污染得到良好控制等内容的详情报告，并根据国际惯例与中方协商恢复出口的条件。

#### 第五条

用于生产向中国输出牛肉的牛须符合下列条件：

(一) 出生并一直饲养于蒙古国口蹄疫非免疫无疫区，具有唯一身份标识，且标识具有可追溯性。

(二) 来自符合下列条件的省份：

1. 经中方正式确认、允许对中国出口牛肉的省份。

2. 在过去 12 个月内，该省份没有从蒙古国的口蹄疫非免疫无疫区以外的地区引进过任何偶蹄类动物。

3. 该省份被纳入了国家残留监控计划，根据计划结果证明，向中国出口的牛肉不含对人体健康的药物、化学残留和其他有毒有害物质残留。

(三) 来自符合下列条件的地区(苏木)：

1. 在过去 6 个月内，该地区(苏木)未因动物疾病受到过检疫限制

或监测。

2.过去 6 个月内，该地区（苏木）没有发生水泡性口炎、蓝舌病、牛结核病、炭疽病、狂犬病、布氏杆菌病、伪狂犬病、Q 热、心水病和副结核病的临床病例。

（四）动物屠宰前至少在最后一个省份饲养了 60 天。动物屠宰前至少 14 天没有接种炭疽活疫苗。

（五）动物从未饲喂过反刍动物成份（奶及奶制品、皮张制成的明胶和胶原、无蛋白和脂肪残留的磷酸二钙除外）的饲料；从未使用过中蒙两国禁止使用的兽药和饲料添加剂。

（六）宰前宰后检验检疫过程中没有显示出任何炭疽、结核病和布氏杆菌病的临床症状或病理变化。如在宰前宰后检验检疫时发现上述疾病，来自同一批牛和同一养殖群体的牛肉不得向中国出口。

#### 第六条

向中华人民共和国输出牛肉的生产企业（包括屠宰、加工和储存企业）应设在蒙方确认的口蹄疫非免疫无疫区、且中方确认允许对中国出口牛肉的省份内，符合中华人民共和国和蒙古国法律法规中有关兽医卫生和公共卫生的要求，由中国国家认证认可监督管理局根据中华人民共和国《进口食品境外生产企业注册管理规定》进行注册。未获得注册的肉类生产企业的产品不得向中国出口。

#### 第七条

蒙古国官方兽医应行使下列职能：

（一）依照蒙古国和中国的有关法律法规对用于生产输华牛肉的牛

实施宰前宰后检验检疫。

(二) 证明所有屠宰动物符合本议定书第四条和第五条的要求，动物是健康的，无动物传染病、寄生虫病的临床症状，胴体和脏器无病理变化。

(三) 证明牛只屠宰后，胴体剔骨前在不低于2°C的环境下经过至少预冷和熟化24小时。经检测，胴体两侧背最长肌中部的pH 值小于5.9，且胴体上的主要淋巴、腺体组织已去除。

(四) 证明肉类产品是在蒙古国官方主管机构的监督下以 HACCP 为基础的质量保证体系下生产的，未受到致病微生物污染，符合蒙古国及中国的法律法规规定。

(五) 证明产品中兽药、农药、重金属及其他有毒有害物质的残留量不超过蒙古国和中国规定的最高残留限量，且不含有中国和蒙古国规定的禁用物质。

(六) 证明产品是卫生、安全的，适合人类食用。

(七) 一旦发现违反(一)至(六)所述，应立即通报中方，暂停相关企业的产品出口。蒙方将调查原因并采取相应整改措施，包括召回可能受污染的产品。

## 第八条

用于屠宰向中华人民共和国输出牛肉的牛，不得与不符合本议定书第四条和第五条规定的牛一起屠宰。向中国输出的牛肉不得与不符合本议定书第四条、第五条和第七条规定的牛肉一起加工。向中国输出的牛肉在加工和储存的各个阶段都应易于识别和追溯，保证只有符合本议定书要求的产品才能出口到中国。向中国输出的牛肉应单独存放在专门的区域。

### 第九条

向中华人民共和国输出的牛肉产品，内外包装必须使用符合国际卫生标准的无毒、无害的全新材料包装，完好无破损；内外包装上应当标明产地国、品名、生产企业注册号、生产批号；外包装上应当以中文标明规格、产地（具体到州/省/市）、目的地、生产日期、保质期、储存温度等内容，目的地应当标明为中华人民共和国，加施蒙古国官方检验检疫标识。

### 第十条

向中国输出的牛肉，从包装、存放到运输的全过程，均应符合卫生条件，防止受有毒有害物质的污染。运输过程中不得经过因发生疫病而受到限制或监测的地区。货物装入集装箱后，应在蒙古国官方兽医检验检疫员的监督下加施铅封，铅封号须在卫生证书中注明。运输过程中不得拆开及更换包装。冷冻肉的中心温度不应高于-18℃。

### 第十一条

向中国输出的每一集装箱牛肉应随附至少一份蒙古国官方出具的正本卫生证书原件，证明该批产品符合蒙古国及中国兽医卫生和公共卫生法律法规及本议定书的有关规定。

卫生证书用中文、蒙文和英文写成，卫生证书的格式、内容须事先经双方确认认可。

蒙方在出具纸质证书的同时，还须及时将证书的电子信息在货物抵达前通过双方确定的方式发送给中方。

## 第十二条

必要时，中方将派出肉类检验检疫监管官员到蒙古国输出牛肉相关的地区（苏木）、肉类生产企业（包括屠宰、加工和储存企业）、实验室、出境口岸等配合蒙方对输华牛肉进行检验检疫。蒙方应提供必要的协助和便利条件。

## 第十三条

向中国输出的牛肉必须经中方指定的进口肉类指定口岸进口。如果中方发现输入的牛肉违反本议定书的有关规定，中方将立即通知蒙方，并根据中国有关法律法规要求，对产品作退回、销毁或其它处理。蒙方将和中方合作调查和解决问题，包括向中方通报已采取的补救措施如召回其它可能有问题的产品，防止此类事件再次发生。

## 第十四条

本议定书所称牛肉是指冷冻的带骨和剔骨牛肉，不包括头部和蹄部、脊髓、脊柱、背根神经节、内脏及其它副产品。

## 第十五条

本议定书经双方协商同意，可以修改。修改部分的生效日期由双方协商决定。

## 第十六条

中方或蒙方中的任何一方可以通过提前六个月向另一方以书面通知的

方式终止本协议定书。

### 第十七条

中方或蒙方中的任一方可以在任何时候通过官方渠道提出磋商的申请。磋商的时间与地点将由双方协商决定。

### 第十八条

本协议定书自签字之日起生效。

本协议定书用每份用蒙文、中文和英文写成，于2016年8月29日在乌兰巴托市签署。三种文本具有同等的法律效力。如存在异议，以英文为准。

蒙古国

国家技术监督总局

代表



中华人民共和国

国家质量监督检验检疫总

代表

